

ӨМНӨД СОЛОНГОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮСРЭНГҮЙ ХӨГЖИЛ БА ТАВАН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНҮҮДИЙН ОНЦЛОГ ШИНЖ

*Б.Оюунсүрэн**

БНСУ-ын Засгийн газраас улс орныхоо нийгэм, эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлт, хөгжлийн стратеги, үйл ажиллагаандаа авч явуулж байсан бодлогууд нь улс орных нь эдийн засаг, нийгэмд ихээхэн өөрчлөлт, шинэчлэлтийг оруулж чадсан билээ. Тиймээс дээрх бодлого үйл ажиллагаатай нь холбогдуулан өнгөрсөн үеийн болон өнөөгийн эдийн засаг, цаашдын хандлагыг судлах нь маш их туршлага, сургамж болох болно.

Монголчууд бид улс орноо хөгжүүлэхийн тулд гар хумжилгүй хөдөлмөрлөхийн сацуу дэлхийн дэвшилтэт, шинэлэг үзэл санаа, техник технологид суралцан, байнга шинийг эрэлхийлэх хэрэгтэй байна. Мөн үсрэнгүй хөгжиж чадсан улс орнуудын арга туршлага, түүхийн хуудсыг сөхөж, түүнээс сургамж авч, бас суралцах ёстой. Тиймээс энэхүү өгүүлэлд БНСУ-ын 1962-1997 оны хооронд эдийн засаг, нийгмийн бодлогодоо авч явуулсан долоон 5 жилийн төлөвлөгөөний онцлог шинж, ололт дутагдлыг тусган харуулахыг хичээсэн болно.

БНСУ 1960-аад оноос үсрэнгүй хөгжиж, дэлхийн хүчирхэг гүрнүүдийн нэг болсон нь дэлхийн аль ч улс орны улс төрчид, судлаачид, жирийн хүмүүсийн сонирхлыг зүй ёсоор татдаг билээ.

Эдийн засаг, нийгмээ хөгжүүлэх Солонгосын таван жилийн төлөвлөгөөнүүд

1950-1960 он. Энэхүү 10 жилийн хугацаанд Солонгос улсад 5 жилийн төлөвлөгөөгөөр эдийн засгаа хөгжүүлэх үйл ажиллагааны эхлэл тавигдаж, 1962 онд шинэ Засгийн газрын удирдлага дор энэ үйл явц өрнөж эхлэв.

Энэхүү хөгжлийн төлөвлөгөөний онцлог шинж нь хувирамтгай байдалд оршиж байв. Өөрөөр хэлбэл засгийн газар урьдаас төлөвлөөгүй зүйлтэй тулгарвал бодлогоо өөрчлөх бэлтгэлтэй байх ба хэрэв шаардлагатай бол 1 жилээр төлөвлөгөөгөө хойшлуулах хэрэгтэй хэмээн үздэг өвөрмөц бодлого гэсэн үг.

Солонгос нь 1962 оноос эдийн засгийн хөгжлийг бодлогынхоо эн тэргүүн эгнээнд тавьж, түүний биелэлтэнд бүх ард түмний хүчийг хандуулах тогтолцоог бий болгосон юм.

* Б.Оюунсүрэн - Улаанбаатар дээд сургууль

Эдийн засгийг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөө нь:

“Эдийн засгийн хоцрогдлыг даван туулж, үндэсний эдийн засгийн бие даасан байдлыг хучирхэгжуулье” гэсэн уриан доор нийтдээ 3 тэрбум воны хөрөнгө оруулсан ба дунджаар 7,1 өсөлтийн хувьтай байна гэсэн нь тухайн үедээ их шахуу зорилт байлаа.

♦ Мөн хоёрдогч боловсруулалтын салбарын үйлдвэрлэлийг 100% илүү өсгөнө гэсэн зоригтой төлөвлөгөө байлаа.

♦ Хөрөнгө оруулалтын хөрөнгийг ард иргэдэд 44%, Засгийн газарт 56%-ийг хуваарилсан бөгөөд ажилгүйдлийг 24-15% хүртэл бууруулахаар төлөвлөсөн байна.

♦ Экспортын зорилт нь төлөвлөсөн оны эцэст 1960 онтой харьцуулбал 4.2 дахин буюу 130 сая ам.доллараар өссөн. Эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөөг эхнээс нь авахуулаад хэрэгжүүлж дуустал Эдийн засгийн төлөвлөлтийн хороо нь тэр үеийн эдийн засаг, санхүүгийн бүхий л асуудлуудыг шийдэж байлаа .

Энэ хугацаанд эдийн засгийн бодлогыг боловсруулан, түүний биелэлтийг хянан удирдаж, эдийн засгийн яам, хороодыг нэгтгэн удирдах байгууллага байхгүй байсан өмнөх жилийн дутагдлыг засахын тулд эдийн засгийн нэгдсэн төлөвлөгөө, түүнтэй зохицсон гүйцэтгэх тогтолцоо болсон Эдийн засгийн төлөвлөлтийн хороог байгуулав. Засгийн газар хувийн аж ахуй, нэгж секторуудад төлөвлөгөөний дагуу тусламж дэмжлэг үзүүлж байжээ.

Анхдугаар таван жилийн төлөвлөгөө нь 1962-1966 оныг хамрах бөгөөд эдгээр жилүүдэд эдийн засаг нь зөвхөн өөрт буй нөөцөө хэрхэн зарцуулах вэ? Эсвэл газрын тосноос олох ашгаа хүлээгээд л гар хумхиад суух уу? гэдэгт анхаарлаа хандуулахгүй, аж үйлдвэрийн тогтолцоог бий болгож үүгээрээ эдийн засгаа хөгжүүлэхээр цемент, нийлэг утас, газрын тосны боловсруулах үйлдвэр, бордооны үйлдвэр, электрон төхөөрөмжийн үйлдвэр зэргийг бий болгож, ажиллуулах зэрэгт гойд анхаарах болов.

II 5 жилийн төлөвлөгөө нь 1967-1971 оныг хамрах бөгөөд эдгээр жилүүдэд өмнөхөөсөө илүү орчин үежсэн аж үйлдвэрийн тогтолцоог бий болгож импортоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүнийг орлож чадахаар зэр зэвсэг, машин, химийн үйлдвэртэй болохыг онцлон үзэж байв.

III таван жилийн төлөвлөгөө нь 1972-1976 оныг хамрах бөгөөд эдгээр жилүүдэд хүнд ба химийн үйлдвэрийг дэмжих экспорт руу чиглэсэн бодлогыг авч хэрэгжүүлэв.

Тухайн үйлдвэрүүдэд төмөр, ган боловсруулах үйлдвэр, агаарын тээврийн машины үйлдвэр, гэр ахуйн электрон барааны үйлдвэр, усан

онгоцны үйлдвэр, химийн үйлдвэр багтаж байв. Хүнд ба химийн үйлдвэрийг хөгжүүлэгчид өөрсдийн үйлдвэрүүдээ гаднаас оруулж буй завсрын импортын бүтээгдэхүүнийг орлуулж чадахуйц экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болгохыг зорьж байв. Ингэснээр гадны капиталыг багасгах, өөрийн орон дахь гадны капиталын нөлөөллийг үгүй хийхийг тусгаж байв.

Солонгосын өмнөд хэсэгт байгуулагдаж байсан хүнд маягийн аж үйлдвэрүүд эдийн засгийн хөгжилд тус дэм болоод зогсохгүй Сөүлийн гаднах аж үйлдвэржилтийг хөхиүлэн дэмжиж буурай хөгжилтэй газар нутгийн оршин суугчдыг ажлын байраар хангах болов.

Үү таван жилийн төлөвлөгөө нь 1977-1981 оныг хамрах бөгөөд эдгээр жилүүдэд дэлхийн аж үйлдвэрийн экспортын зах зээлд хүчтэй өрсөлдөж чадахуйц үйлдвэрүүдийг дэмжих бодлого хэрэгжүүлэх болов.

Эдгээр чухал стратеги бүхий үйлдвэрүүдэд:

- Усан онгоцны үйлдвэр
- Электроны үйлдвэр
- Машины үйлдвэр гэх мэт чадварлаг ажиллах хүч бүхий үйлдвэрүүд багтдаг.

Энэхүү төлөвлөгөөнд төмөрлөгийн бус металл боловсруулах үйлдвэр, болд ган боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрүүд онцлон тусгагдсан байв.

Үүний үр дүнд 1981 оны байдлаар хүнд ба химийн үйлдвэрээс гарч буй бүтээгдэхүүний нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүний дотор эзлэх хувь нь 58.5% хүрчээ. Тухайн үед Солонгос улс өндөр чанартай, хямд үнэтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж байснаараа усан онгоц, гангийн экспортод нь нилээд нааштай хандлага үзэгдэх боллоо. 1970 оны сүүлээр дэлхийн өндөр хөгжилтэй улсуудын хүнд ба химийн үйлдвэрийн тоо эрс буурч эхлэв. Харин Солонгос улсын хувьд засгийн газраас дотоодын машин механизм үйлдвэрлэгчдэд татварын хөнгөлөлтийг үзүүлэх, гадны импортоос хамгаалах, санхүүгийн тусламж үзүүлэх зэрэг хөтөлбөрийг авч хэрэгжүүлснээр үйлдвэрлэгчдийн хувьд ашигт ажиллагаа бий болсоор байв.

1970 оны сүүлээр газрын тосны үнэ өсөж улмаар инфляцийг хөөрөгдүүлснээр дэлхий нийтээрээ эдийн засгийн хямралтай тулгарав. Солонгос улсын аж үйлдвэрийн тогтолцоо тэнцвэргүй болж барилгын материал, өдөр тутмын хэрэглээний зүйлс ховордох болов. Хүнд ба химийн үйлдвэрийн салбарт ажиллаж буй маш олон компаниуд төлөвлөгөөний дагуу шаардлага бүхий эрэлт хэрэгцээг хангах чадал нь хүрэхгүй байсан учир өрийн дарамтаас айж байв. Санхүүгийн салбарууд ч гэсэн айдастай тулгарав.

Бүхэл бүтэн 1970 оны туршид ийм байдалтай байсны эцэст засгийн газар арга буюу зээлийн картны системийг бий болгож аж үйлдвэрийн тоног төхөөрөмжийг банкны зээлээр олгох бодлого хэрэгжүүлэх болов. Энэхүү зээлийн систем нь газрын тосны үнийн өсөлт, өндөр инфляцийн дарамт, хяналтгүй өмч хөрөнгө бий болсон үед ч гэсэн хүнд ба химийн үйлдвэрээс гол ашгаа олж буй эдийн засгийн хүчин чадал бүхий томоохон бизнесийн байгууллагууд, орлого хөрөнгийн тэнцвэргүй байдалд анхаарлаа хандуулж байв. Гэсэн хэдий ч Солонгосын эдийн засаг баталгаагүй байсаар л байв.

1982-1986 оныг хамарсан Ү таван жилийн төлөвлөгөөний онцлог шинж нь макро эдийн засгийн тогтворжилт ба либералчлалд оршиж байв.

Эдгээр нь юу вэ гэвэл:

- Санхүүгийн либералчлал
- Гадаад худалдааны либералчлал
- Зах зээл дэх чөлөөт өрсөлдөөний бодлого юм.

Тус улс нь цаашид хүнд ба химийн аж үйлдвэрээс эрчимтэй технологи бүхий нарийн машин механизм, телевизор, видео кассет тоглуулагч, хагас дамжуулагч гэх мэт электрон тоног төхөөрөмжийн үйлдвэр рүү шилжихийг оролдох болов. Зорилго нь юу байв гэвэл дэлхийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй сайн технологитой бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж гаргахад оршиж байв.

ҮI таван жилийн төлөвлөгөө нь 1987-1991 оныг хамардаг. Тухайн жилүүдэд өмнөх жилийн төлөвлөгөөнүүдэд тусгагдсан арга хэмжээнүүдийг арай өргөн цар хүрээтэйгээр авч хэрэгжүүлэхээр болов.

Засгийн газар аль болохоор битүүлэг байдлаасаа ангижрахын тулд импортын либералчлалыг хурдасгах импортыг татварын бэрхшээлээс ангижруулахыг зорьж байлаа.

Үүний зэрэгцээ Засгийн газар бүх үйлдвэрүүдэд бус гагцхүү тодорхой үйлдвэрүүдэд үе шаттай туслахаар амлав. Ялангуяа өмнө нь жижиг дунд үйлдвэрүүд засгийн газрын тусламж дэмжлэгийг хүртдэггүй байсан жишээтэй.

Засгийн газар шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхээр зорьж хөрөнгө оруулалтынхаа хэмжээг нэмсэнээр тус зүйл биелэлээ олно гэдэгт итгэж байсан ба хөрөнгө оруулалтаа дотоодын нийт бүтээгдэхүүний 2,4%-иас 1991 онд 3% хүртэл нэмэгдүүлэхээр болов.

ҮII таван жилийн төлөвлөгөө нь 1992-1996 оныг хамардаг. Энэхүү төлөвлөгөөг 1989 онд нарийвчлан боловсруулсан байна. Эдгээр жилүүдэд:

- Микро электроникс
- Хими

- Хараа зүй

- Дэлхийн агаар мандал

- Биоинженерчлэл гэх мэт өндөр технологи шаардсан салбаруудыг хөгжүүлэхээр зорив.

Солонгос улсын засгийн газар улс орон даяар аж үйлдвэржилтийг газар зүйн хувьд тэнцвэртэй байгуулахын тулд алслагдсан орон нутгийн 7 хотод өндөр технологийн дэмжлэг үзүүлэх болов.

1993 онд Ким Юн Санаар удирдуулсан шинэ засгийн газар бий болж тус шинэ засгийн газрын эдийн засагт авч явуулах бодлого нь мөн л 5 жилийн хугацаатай байв. 1993-1997 оныг хамрах шинэ эдийн засгийн 5 жилийн төлөвлөгөөнд

- Бизнесийн үйл ажиллагаан дахь дүрэм журмыг хөнгөвчлөх

- Засгийн газраас эдийн засагт үзүүлэх үйлчилгээнд өөрчлөлт оруулахыг голлох болов.

Төлөвлөгөөнд заагдсан ёсоор гаднаас орж ирж буй бүтээгдэхүүний гаалиар нэвтрэх бэрхшээл багасч өрсөлдөөнд оролцох хязгаарлагдмал байдал нь үгүй болж байв. Үүнд “согтууруулах ундаа, газрын татвар, тээвэр, барилга, байгууламж, санхүүгийн салбарууд” багтаж байлаа.

Гэсэн хэдий ч өнгөрсөн жилүүдийн нөр их хичээл зүтгэл нь дээд албан тушаалын хүнд сурталтнуудын үйл ажиллагаагаар уналтанд орж эхлэв. Юу гэвэл зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлэх гэсэн бодлого амжилтгүй боллоо.

Солонгосын 5 жилийн төлөвлөгөөний макро эдийн засаг дахь гүйцэтгэл амжилттай болгосон хүчин зүйлүүд

- Өндөр чанартай боловсрол

- Чадварлаг ажиллах хүчин

- Гадаадын капиталын урсгалыг хязгаарлахгүй байх явдал

- Хүчирхэг хувь нийлүүлсэн хамтрагч

- Идэвхтэй СОС хөрөнгө оруулалт ба бага хөлс

- Олон улсын байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаан дахь оролцоо

Энэ бүх эдийн засгийн эрчимтэй өсөлт нь стратегийн төлөвлөгөөний дагуу явагдаж байсан боловч Солонгосын эдийн засагт дараах асуудлууд оршиж байлаа.

- Аж үйлдвэр дэх улс төрийн бодлогоос нөөцийг хувиарлахгүй байх

- Засгийн газрын бүтэлгүйтэл

- Эдийн засаг дахь төрийн бодлогын шийдвэр тодорхой бус байх.

- Корпорацийн удирдлагын бүтэлгүйтэл

- Санхүүгийн зах зээлийг нээх бэлтгэлгүй байв.

5 жилийн хөгжлийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд бодит хөрөнгө оруулалт Засгийн газарт шаардлагатай байв. Ингээд эдийн засгийг хөгжүүлж чадах тодорхой 5 аж үйлдвэрийн салбарыг сонгож, тэдэнд хүртээх санхүүгийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг зохиов. Үүний дараа тэдний гаргасан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний ихэнх нь үр дүнгүй, бүтэл муутай боллоо.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө бүтэлгүйтсэн эхний шалтгаан нь нарийн нягт тооцоогүй, оновчгүй салбарт хөрөнгө оруулсан үр дүнгүй хөрөнгө оруулалт зэрэг байв.

Энэхүү 5 жилийн хөгжлийн төлөвлөгөөг эргээд харахад эерэг, сөрөг талын аль алиныг агуулсан мэт.

Эерэг буюу оновчтой тал нь гэвэл:

1. Засгийн газар түргэн өсөлттэй машин механизм, хөдөлгүүрийг экспортлоход нилээд анхаарах болов. Энэ нь тухайн үедээ улс орныг хөгжүүлэх гол чиглэл болж өгөв.

2. Төлөвлөгөөнд заагдсанаар хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих болов. Үүнийг дагаад зах зээлийн үйл ажиллагаанд хяналт зохицуулалт хийдэг хуулийн институтууд мөн нийгмийн бусад байгууламжууд ч гэсэн хөгжих болов.

Сөрөг талуудыг нь авч үзье.

5 жилийн төлөвлөгөөндөө юуны өмнө үйлдвэр, хөрөнгө оруулалт, хуримтлал зэргийг илүү түлхүү оруулж өгсөн нь олон дампуурсан үйлдвэрүүдийг бий болгосон бөгөөд үйлдвэрүүд зах зээлээ мэдэрч үйл ажиллагаагаа явуулах бус гагцхүү засгийн газрын зээл тусламжийг горьдогчид болов. Тухайн үедээ засгийн газар, пүүс компаниуд хоорондын харилцаа нь дүрэм журмаас илүүтэйгээр бие биенээсээ болгоомжилсон байдалтай байлаа.

Солонгосын засгийн газар төлөвлөсөн төлөвлөгөөндөө хүрэхээр эрмэлзэж байсан бөгөөд энэ бүхнээс нь болоод зах зээлийн гажилт бий болсон. Жишээ нь: хөрөнгө оруулалтын санг бүрдүүлэхийн тулд зээлийн хувь ноогдуулах болов. Энэхүү шахалт бүхий эдийн засаг нь нэг талаараа бүтэмжтэй, хүмүүст шударга хандаж байгаа юм шиг атлаа инфляцийн өсөлтийг хурдасгаж байлаа.

Засгийн газрын мөнгөний ханш дахь оролцоо ба зээлийн хуваарилалт нь аж үйлдвэрийн хөгжилд харшлах болов. Засгийн газрын шийдвэрийн дагуу явагдаж байсан нөөцийн хуваарилалт нь монополь ба олигополь зах зээлийг хөхиүлэн дэмжиж байв.

Солонгосын засгийн газар эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөнийхөө дараагийн шатанд орохгүй байсаар л байна. Үүнд цөөн хэдэн шалтгаан бий.

Юуны өмнө Солонгос дахь хувийн хэвшлийнхэн хүчээ авч эхэлсэн учир сул дорой жижиг хувийн секторууд засгийн газраас хараат бус болж, өөрсдөдөө хөрөнгө оруулах чадвартай болсоор байсан учир засгийн газрын удирдлага бүхий төлөвлөгөө үр дүнгүй болсон.

ДҮГНЭЛТ

Солонгосын эдийн засаг өнгөрсөн 40 жилийн хугацаанд дэлхийн олон орныг атаархуулам эдийн засгийн хөгжилд хүрч чадсан байна. 1962 оноос эхлэн 7 удаагийн 5 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаанд Солонгос улс дэлхий нийтийн анхаарлыг татсан шинэ аж үйлдвэржсэн орон болж, одоо хөгжиж буй орноос хөгжингүй орон болох шатандаа явж байна.

Солонгос улс шиг 40 жилийн асар богино хугацаанд газар тариалангийн орноос хүнд, дунд үйлдвэр хөгжсөн аж үйлдвэрлэлийн орон болж, орлого болон амьдралын түвшингөө эрс сайжруулж чадсан улс гэвэл энэ XX зуунд ч хуруу дарам цөөн билээ.

Монгол Улс эрчимтэй хөгжлийн шинэ үе шатандаа дэвшин орж буй өнөөгийн нөхцөлд Солонгос орны зах зээлийн тогтолцоог, төрийн зохицуулалт, таван жилийн төлөвлөлттэй уялдуулан хөгжүүлэх гэсэн бодлого, үйл ажиллагааны эерэг сөрөг талууд, ололт амжилт, алдаа дутагдлыг сайтар бүтээлчээр судлан, БНСУ-ын хөгжлөөс туршлага, сургамж авах зайлшгүй шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Ашигласан материал:

1. Ким Юхиөг “Шинэ тосгон хөдөлгөөн ба гэр загварт хот”
2. Сун Бённаг “Солонгос, солонгос хүн, солонгосын эдийн засаг” 1993 он
3. “Солонгосын түүхэн замнал буюу 1960-1990 он хүртлэх Солонгосын нийгэм, эдийн засгийн байдал “ 1999
4. “Монгол, Солонгос хоёр орны түүх, соёл, нийгмийн харилцаа” Зүүн хойт Азийн Олон улсын ассиосацийн 2006 оны гуравдугаар уулзалт. УБ., 2006
5. Seong Min Hong, Ph. D. “Modernization and Economic Development in the Korean Economy “- 1992
6. <http://www.adb.org>
7. www.nso.go.kr
8. www.bok.or.kr
9. www.mongolia-gateway.mn